



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 135

Өлгий сум

Аймгийн нутаг дэвсгэрээс 2023 онд ахуйн зориулалтаар
агнах, барих загасны дээд хязгаар тогтоох тухай

Монгол Улсын Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаар батлах тухай" 2023 оны А/05 дугаартай тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арван хоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Тус аймгийн нутаг дэвсгэрээс 2023 онд ахуйн зориулалтаар агнах, барих загасны дээд хязгаарыг нэгдүгээр, агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг хоёрдугаар, үйлдвэрлэлийн зориулалтаар агнах загасны хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50 хувийг хуулийн дагуу тухайн агнуурын бүс нутгийн амьтны амьдрах орчныг нөхөн сэргээх, тэтгэх, агнуурын амьтны судалгаа, мониторинг хийх зэрэг арга хэмжээнд зарцуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Ахуйн зориулалтаар ан амьтан агнах, барих ажлыг дээд хязгаарт багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш. Марат), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Х.Арман)-д даалгасугай.

ДАРГА

Н.БЕЙБИТХАН

2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн
аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит арван хоёрдугаар хуралдааны
135 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

2023 ОНД АХУЙН ЗОРИУЛАЛТААР БАРИХ
ЗАГАСНЫ ТОО ХЭМЖЭЭНИЙ ДЭЭД ХЯЗГААР

№	Сумын нэр	Загас барих газрын нэр	Загасны хэмжээ /ширхэг/
1	Алтай	Сагсай гол	150
2	Алтанцөгц	Ховд гол	100
3	Буянт	Сагсай гол	100
4	Бугат	Ховд гол	100
5	Булган	Булган гол	0
6	Дэлүүн	Тал нуур	500
7	Улаанхус	Ховд гол	100
8	Цэнгэл	Ховд гол	100
9	Толбо	Толбо нуур	500
10	Ногооннуур	Ховд гол	100
11	Баяннуур	Ховд гол	100
12	Сагсай	Ховд гол	100
13	Өлгий	Ховд гол	100
	Дүн		2000

2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн
аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит арван хоёрдугаар хуралдааны
125 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

2023 ОНД АХУЙН ЗОРИУЛАЛТААР АГНАХ, БАРИХ
АМЬТНЫ ТОО ХЭМЖЭЭНИЙ ДЭЭД ХЯЗГААР

№	Сумын нэр	Агнах, барих амьтны хэмжээ /ширхэг/	
		Саарал чоно	Шар үнэг
1	Алтай	2	3
2	Алтанцөгц	3	3
3	Буянт	2	2
4	Бугат	2	3
5	Булган	2	-
6	Дэлүүн	3	3
7	Улаанхус	2	3
8	Цэнгэл	3	3
9	Толбо	2	2
10	Ногооннуур	3	3
11	Баяннуур	3	2
12	Сагсай	3	3
Дүн		30	30

2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн
аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит арван хоёрдугаар хуралдааны
185 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

2023 ОНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТААР
АГНАХ ЗАГАСНЫ ХЭМЖЭЭ

№	Сумын нэр	Нуурын нэр	Загасны зүйл	Хэмжээ/тонн/
1	Толбо	Толбо	Нохой сугас, шар сугас	15
	Нийт			15